

## 2014 ОНЫ 8 ДУГААР САРЫН ДААТГАЛЫН МЭДЭЭ

2014 оны 09 дугаар сарын 24

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2014 оны 8 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн бүртгэлд дараах өөрчлөлт орсон байна.

/тоогоор/

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2014.08.01	Нэмэгдсэн	Хасагдсан	2014.08.31
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	254			254
3	Даатгалын компанийн төлөөлөгчийн газар	7			7
4	Даатгалын зуучлагч	25	1 <sup>3</sup>		26
5	Даатгалын зуучлагч компанийн салбар	78			78
6	Даатгалын хохирол үнэлэгч	19			19
7	Даатгалын хохирол үнэлэгч компанийн салбар	11	7 <sup>4</sup>		18
8	Даатгалын төлөөлөгч	3375	49 <sup>1</sup>	1 <sup>2</sup>	3423
9	Актуарч	15			15
10	Жолоочийн даатгалын зөвшөөрөл	16			16

<sup>1</sup>Хорооны даргын 2014 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 229 дүгээр тушаалаар “Хаан даатгал” ХХК-ийн 1 иргэнд, мөн өдрийн 230 дугаар тушаалаар “Бодь даатгал” ХХК-ийн 7 иргэнд, Хорооны даргын 2014 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 233 дугаар тушаалаар “Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-ийн 41 иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

<sup>2</sup>Хорооны даргын 2014 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 226 дугаар тушаалаар “Мандал женерал” ХХК-ийн 1 иргэний даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон байна.

<sup>3</sup>Хорооны 2014 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 292 дугаар тогтоолоор “Ариг банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон байна.

<sup>4</sup>Хорооны даргын 2014 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 223 дугаар тушаалаар “Вендо” ХХК-д Нийслэлийн Сүхбаатар дүүрэг, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Дорнод аймгийн Чойбалсан сум, Хэнтий аймгийн Өндөр хаан сум, Дархан-Уул аймгийн Дархан сум, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сайншанд суманд тус тус даатгалын хохирол үнэлэгчийн салбар нээн ажиллуулахыг тус тус зөвшөөрсөн байна.

## 1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2014 оны 08 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг сарын болон өссөн дүнгээр харуулбал дараах байдалтай байна.

### Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.08.31 /сарын дүн/	2014.08.31 /өссөн дүн/
Даатгалын нийт хураамж	5 801 026 848,52	66 871 059 560,77
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж	830 362 767,53	12 939 138 018,64
Олгосон нийт нөхөн төлбөр	2 625 470 460,30	19 968 847 203,08
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	871 579 938,16	7 939 937 434,21
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо	1 857,00	18 787,00
Давхар даатгалд төлсөн хураамж	5 617 705 097,08	26 893 715 903,68
Байгуулсан даатгалын гэрээний тоо	61 217,00	784 716,00
Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний тоо	20 110,00	282 507,00
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо	21 810,00	351 475,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	199 025 817 418,31	199 025 817 418,31
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөр	145 933 562,17	145 933 562,17

2014 оны 08 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хураамжийн орлого 66871.1 сая төгрөг, үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж 12939.1 сая төгрөг, олгосон нөхөн төлбөр 19968.8 сая төгрөг ба үүнээс жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 7939.9 сая төгрөг болсон байна. Эндээс даатгалын хохирлын харьцаа өссөн дүнгээр 29.8 хувь болсон бөгөөд сарын дүнгээр 45.2 хувь байна.

Өмнөх оны мөн үетэй /сарын дүнгээр/ дээрх үзүүлэлтүүдийг харьцуулахад даатгалын хураамжийн орлого 939.9 сая төгрөгөөр буюу 1.2 дахин буурч, жолоочийн хариуцлагын даатгал 78.9 сая төгрөгөөр буюу 1.1 дахин, олгосон нөхөн төлбөр 705.9 сая төгрөгөөр буюу 1.4 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр 237.3 сая төгрөгөөр буюу 1.4 дахин тус тус нэмэгдсэн байна.

Ердийн даатгалын компаниудын 2014 оны 08 дугаар сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Монгол даатгал” ХХК-ийн даатгалын 199.0 тэрбум төгрөгийн үнэлгээтэй гэрээ юм. Мөн хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК 145.9 сая төгрөгийг олгосон байна.

**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2014/08/31 сарын дүн	2014/08/31 өссөн дүн
Даатгалын нийт хураамж	22 706 349,00	987 735 149,38
Олгосон нийт нөхөн төлбөр	31 222 719,00	321 739 237,00
Давхар даатгалд төлсөн хураамж	88 656,00	15 962 708,00
Байгуулсан даатгалын гэрээний тоо	12,00	205,00
Насан туршийн даатгал	1,00	9,00
Эрүүл мэндийн даатгалд	2,00	12,00
Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд	0,00	14,00
Тэтгэврийн даатгалд	0,00	6,00
Орон сууцны даатгалд	0,00	1,00
Хуримтлалын даатгалд	1,00	1,00
Зээлдэгчийн амь насны даатгалд	8,00	162,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ	1,00	11,00
Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	450 000 000,00	3 495 000 000,00
Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	8 000 001,00	8 000 001,00

Урт хугацааны даатгагч 2014 оны 08 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 987.0 сая төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 397.8 сая төгрөгөөр буюу 1.7 дахин, нөхөн төлбөр 198.4 сая төгрөгөөр буюу 2.6 дахин нэмэгдсэн байна. Даатгалын хохирлын харьцаа 32.5 хувьтай байна.

**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.08.31 /сарын дүн/	2014.08.31 /өссөн дүн/
Нийт орлого	179 914 254 545,54	652 062 343 885,78
Даатгалын зуучлагчийн орлого	329 442 254,41	2 056 394 409,85
Үүнээс: Сайн дурын даатгал	206 987 489,46	941 203 432,05
Албан журмын даатгал	122 454 764,95	1 100 221 802,71
Даатгуулагчаас зуучлагчаар дамжин төлсөн даатгалын хураамж	736 698 644,85	5 235 980 921,09
Зуучилсан даатгалын гэрээний тоо	16 158,00	117 143,00
Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээ	94 305 302 445,68	104 945 412 000,00

2014 оны 08 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд / өссөн дүнгээр/ 2056.4 сая төгрөг, /сарын дүнгээр/ 329.4 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлоготой ажилласан байна. Үүний 63.0 хувийг сайн дурын даатгалаас үлдсэн хувийг албан журмын даатгалын хураамжийн орлогоос бүрдүүлсэн байна. “Капитал банк” ХХК хамгийн өндөр үнэлгээтэй буюу 94.3 тэрбум төгрөгийн даатгалын гэрээг зуучилсан байна.

Даатгалын зуучлагч компаниудаас “Худалдаа хөгжлийн банк” ХХК, “Эм жи ай би” ХХК, “Юу ай би” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК, “Эс ай би эс” ХХК, “Пийс оф лайф” ХХК, “Аме” ХХК, “Ар Эм Ай би” ХХК-иуд тус тус орлогогүй ажилласан байна.

### Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2014.08.31 /сарын дүн/	2014.08.31 /өссөн дүн/
Нийт орлого	92 987 282,61	584 332 335,21
Даатгалын хохирол үнэлгээний орлого	51 201 777,00	309 836 266,34
Үүнээс: Сайн дурын даатгал	13 679 388,90	93 332 074,55
Албан журмын даатгал	37 612 388,10	215 103 691,79
Үнэлсэн даатгалын хохирлын тоо	1 898,00	15 212,00
Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	45 512 800,00	45 512 800,00

2014 оны 08 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ даатгалын хохирол үнэлэгч компаниуд 92.9 сая төгрөгийн хохирол үнэлгээний орлоготой ажилласан байна. Үүнээс 55.1 хувийг сайн дурын, үлдсэн хувийг албан журмын даатгалын хохирлын үнэлгээний орлогоос төвлөрүүлсэн байна.

“Итгэлт эстимэйт” ХХК нь даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн болох 45.5 сая төгрөгийн үнэлгээг хийсэн байна.

### Бусад

Хорооны 2014 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 291 дүгээр тогтоолоор “Сүлд-Аудит” ХХК-ийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгосон.

Хорооны 2014 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор “Моннис даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрсөн. Мөн өдрийн 302 дугаар тогтоолоор “Ард даатгал” ХХК-д хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрч, 303 дугаар тогтоолоор Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байна.

### ДААТГАЛЫН ГАЗРЫН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС